

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ БУЮУ УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Г.НАНДИНЖАРГАЛЫН ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ
БИЕЛЭЛТЭД 2018 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР ХИЙСЭН ХЯНАЛТ
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2018 оны 07 дугаар сарын 17-ны өдөр

Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын дагуу Төсвийн ерөнхийлөн захирагч /Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд/-аас Төсвийн шууд захирагч /Төрийн нарийн бичгийн дарга/-тай байгуулсан 2018 оны үр дүнгийн гэрээний биелэлтэд эхний хагас жилийн байдлаар хяналт шинжилгээ хийж, үр дүнд үнэлэлт дүгнэлт өгөв.

Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны үр дүнгийн гэрээний
эхний хагас жилийн биелэлтэнд өгсөн үнэлгээ

Хүснэгт 1

Үр дүнгийн гэрээний үзүүлэлт	Өгвөл зохих оноо	Гэрээний биелэлтийг хянаж үзэн өгсөн оноо
1. Нийт ажил үйлчилгээ /тусгай захиалгат ажил үйлчилгээнээс бусад/	0-30	25.0
1. Тусгай захиалгат ажил үйлчилгээ	0-40	31.2
2. Манлайллын зорилтын биелэлт	0-30	30.0
НИЙТ ОНОО	0-100	86.2

Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны үр дүнгийн гэрээний
эхний хагас жилийн биелэлтийн үзүүлэлт

Хүснэгт 2

№	Арга хэмжээний нэр	Ажил үйлчилгээний тоо	Төлөвлөсөн арга хэмжээний биелэлт, хувь								Биелэлтийн хувь, %	Үнэлгээний оноо
			100 %	90 %	70%	50%	30%	10%	0	Үнэлэх боломжгүй		
1	Нийт ажил үйлчилгээ	94	41	19	16	7	7	-	-	4	83.2	25.0
2	Тусгай захиалгат ажил үйлчилгээ	111	41	19	20	15	8	1	1	6	78.2	31.2
3	Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтын хүрээнд	7	7	-	-	-	-	-	-	-	100	30
	Дүн	212	89	38	36	22	15	1	1	10	87.1	86.2

1.2.1 Нийт арга хэмжээ

Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулсан Үр дүнгийн гэрээнд тусгай захиалгат ажил үйлчилгээнээс бусад 94 арга хэмжээг 2018 оны эхний хагас жилийн байдлаар гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг тооцсоны үндсэн дээр нэр төрөл бүрээр 0-30 хүртэл оноогоор үнэлэхэд 41 ажил үйлчилгээ үр дүнтэй буюу 100 хувийн биелэлттэй, 19 ажил үйлчилгээ тодорхой үр дүнд хүрсэн буюу 90-99 хувийн биелэлттэй, 30 ажил үйлчилгээ эрчимжүүлэх шаардлагатай буюу 31-79 хувийн биелэлттэй, үнэлэх боломжгүй 4 ажил үйлчилгээ байна. Үнэлгээний оноо: **25.0**

1.2.2 Тусгай захиалгат арга хэмжээ

Гэрээний тусгай захиалгат ажил үйлчилгээний нийлүүлэлтийг дүгнэхдээ 2018 оны эхний хагас жилийн ажил үйлчилгээг үндэслэн Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний бодлого, зорилтыг хэрэгжүүлэхэд тухайн жилд ач холбогдолтой гэж үзсэн ажил үйлчилгээг арга хэмжээ тус бүрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт болон хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг тооцсоны үндсэн дээр арга хэмжээ тус бүрийн биелэлтэд 0-40 онооны үнэлгээ өгч, тусгай захиалгат ажил үйлчилгээний дундаж оноог гаргав.

41 ажил үйлчилгээ үр дүнтэй буюу 100 хувийн биелэлттэй, 19 ажил үйлчилгээ тодорхой үр дүнд хүрсэн буюу 90-99 хувийн биелэлттэй, 43 ажил үйлчилгээ эрчимжүүлэх шаардлагатай буюу 31-79 хувийн биелэлттэй, хэрэгжээгүй 1 ажил, үнэлэх боломжгүй 6 ажил үйлчилгээ байна. Үнэлгээний оноо: **31.2**

Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргалын үр дүнгийн гэрээний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, биелэлт нь **86.2** оноо авсан тул Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын дагуу “В” буюу “Сайн” гэж үнэлсэн.

Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээг дүгнэсэн тухай илтгэх хуудас хавсаргав.

ДҮГНЭЛТ

1. Үр дүнгийн гэрээний илтгэх хуудсыг Төрийн албаны зөвлөлөөс баталсан “Менежерийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам”-ын 2 дугаар хавсралтын дагуу тайлагнах, тогтоосон хугацаанд ХШҮДАГ-т ирүүлж байх шаардлагатай байна. Тухайлбал,
 - ТНБД-ын ҮДГ-нд нийт болон тусгай арга хэмжээнүүд холилдсон байна. Тухайлбал, нийт арга хэмжээнд тусгай арга хэмжээний 3.3.1, 6.1.3, 6.1.4, 6.2.1, 6.4.1, 7.1.10, 7.2.2, тусгай арга хэмжээнд нийт арга хэмжээний 2.2.7, 6.1.5, 6.2.2, 6.2.3, 6.3.4, 6.3.5, 7.2.1 дугаартай ажил үйлчилгээнүүд тус тус байна.
 - Газар /нэгж/-ын ажил үйлчилгээний дугаар болон ТНБД-ын гэрээний ажил үйлчилгээний дугаар хоорондоо зөрж байна. Тухайлбал, ГБГ-ын 2.1.12 дугаартай ажил үйлчилгээ ТНБД-ын гэрээнд 2.1.9 дугаартай байна.
 - ХҮБГ-ын даргын гэрээнд тусгагдсан арга хэмжээнүүд 1 дугаартай байна. /ТНБД-ын гэрээнд 5 дугаартай тусгагдсан/
 - ТНБД-ын гэрээний 2.1.6 - 2.1.13 дугаартай ажил үйлчилгээний биелэлт ГБГ-ын даргын гэрээний биелэлттэй зөрсөн байна. Мөн 6.3.5 дугаартай ажил үйлчилгээний биелэлтийг нэгтгэлд оруулаагүй байна.
2. Хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүдийн зорилго, арга хэмжээг багцлан, яамны үйл ажиллагааны төлөвлөгөөг тодорхойлох шаардлагатай байна.

3. Яамны болон нэгжийн төлөвлөгөөнд шалгуур үзүүлэлтийг ерөнхий “жилдээ” гэж төлөвлөж байгаа нь бодлогын зарим баримт бичгүүдийн зорилго, зорилт хэрэгжихгүй удаашрах нөхцөл байдлыг үүсгэж байна.
4. Яамны нэгжүүд ҮДГ-ний биелэлт гаргахдаа толгойлон хэрэгжүүлэх нэгжид хамтран хэрэгжүүлсэн нэгжүүд өөрийн оролцоо болон хийсэн ажлуудын мэдээллийг хүргүүлж ажиллаагүй, мөн хамтран хэрэгжүүлсэн нэгжүүд нь гэрээний биелэлтдээ тусган тайлагнаагүй байна.
5. Тайлант онд үргэлжлэн хэрэгждэг ажил үйлчилгээнүүдийг хугацаа болоогүй гэсэн нь учир дутагдалтай байна.
6. Ажил үйлчилгээний биелэлтийг оновчтой тайлагнаж, тодорхой тоо баримтаар илэрхийлж хэвших /тухайлбал, 6.4.4, 1.1.1.8, 1.1.1.9/
7. Төсвийн шууд захирагчийн 2018 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлуудаас дараах ажлууд удааширсан явцтай байна. Үүнд:
 - 2.1.3. Цацраг идэвхт ашигт малтмал болон газрын ховор элементийн хайгуул судалгаа, ашиглалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.
 - 3.2.1 “Ил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн төслийг шинэчлэн боловсруулах
 - 3.2.2 “Ашигт малтмалыг баяжуулах, ялгах бутлах ба хүдэр, баяжмалыг бөөнцөглөх аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн төслийг боловсруулах
 - 3.3.6. Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх
 - 3.3.12. Эрдэс баялгийн салбарын хөгжлийн үндэсний хөтөлбөр боловсруулна.
 - 4.1.7. “Газрын тосны тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-т заасан “Газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлага” журмыг боловсруулж, батлуулна.
 - 5.1.7. Хүнд үйлдвэрийн салбарын аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг жигдрүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Бүртгэлийг шинэчилж, санал боловсруулсан байна.
 - 5.1.5. Хүнд үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгоно. Хүнд үйлдвэрийн тухай хуулийн төслийг боловсруулж, хуулийн үзэл баримтлалыг батлуулсан байна.
 - 5.1.6. Хүнд үйлдвэрийн аюулгүй ажиллагааны дүрмийн төслийг боловсруулна. Хүнд үйлдвэрийн аюулгүй ажиллагааны дүрмийг боловсруулсан байна.
 - 5.2.1. Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах уралдаант шалгаруулалтыг зохион байгуулна. Хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан байна.
 - 5.2.2. Үйлдвэрийн нарийвчилсан зураг төслийн ажлыг хийнэ. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэлийн ажлын даалгавар боловсруулсан байна.
 - 5.2.6. Төмөртэйн уурхайд хуурай болон нойтон соронзон баяжуулах үйлдвэр байгуулна. Үйлдвэрийн барилгын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлын явцад хяналт тавьсан байна.
 - 5.2.7. Гангийн үйлдвэрлэлийн бизнесийн таатай орчныг бүрдүүлж, төмөрлөгийн үйлдвэрүүдийн ашиглалтыг сайжруулж, импортын хэмжээг бууруулна. Дотоодын төмөрлөг боловсруулах үйлдвэрүүдийн ашиглалтыг сайжруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чиглэлээр санал боловсруулсан байна.
 - 5.2.9. Автомашин, машин механизм угсрах, автомашины эд анги үйлдвэрлэх үйлдвэр, технологийн парк байгуулахыг бодлогоор дэмжинэ. Парк байгуулах боломж, нөхцөлийн талаар дэлгэрэнгүй судалгаа хийх ажлыг зохион байгуулсан байна.

- 5.3.5. Төслийн санхүүжилт, хөрөнгө оруулалт, хувь эзэмшлийн хэмжээний талаар санал боловсруулах, холбогдох шийдвэрийг гаргуулах, төсөл хэрэгжүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах бэлтгэлийг хангана. Төслийн санхүүжилт, хөрөнгө оруулалт, хувь эзэмшлийн хэмжээний талаар санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлсэн байна. Хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах бэлтгэл ажил хангагдсан байна.
 - 5.3.7. Улаанбаатар хотод жилд 15000 тн тос, тосолгооны материал үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр байгуулахыг дэмжинэ. Холбогдох судалгааны ажлыг хийж эхэлсэн байна.
 - 5.3.8. Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу бүлэг ордыг ашиглах төслүүдийг эрчимжүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах, уул уурхайн дэд бүтцийг цогцоор нь хөгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлүүлнэ. Хөтөлбөрийн хэрэгжилт төлөвлөгөөний дагуу хангагдсан байна.
 - 5.3.9. Био болон эко түлшний үйлдвэрлэлийг дэмжинэ. Дэмжлэг үзүүлсэн байна.
 - 6.2.2. Цацраг идэвхт ашигт малтмал болон газрын ховор элементийн нөөц бүхий ордод стратегийн хөрөнгө оруулагчдыг сонгох, хамтарсан компани байгуулна.
7. Үр дүнгийн гэрээний биелэлтийг бүрэн, гүйцэд, бусад ажил үйлчилгээний гүйцэтгэлтэй уялдуулж тайлагнах шаардлагатай байна. Үүнд:
- Гэрээний 3.1.3. "Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулах" ажлын биелэлтийг "Уул уурхайн тухай хуулийн төсөлд Ил тод байдлын асуудлаар бүлэг оруулж, боловсруулсан" гэж тайлагнажээ. Гэтэл 3.1.1-д: "Уул уурхайн тухай хуулийн төслийг батлагдсан үзэл баримтлалын дагуу боловсруулах" ажлын биелэлтийг "Хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулсан. Хуулийн хэлтсийн дарга Н.Баярчимэг, сайдын зөвлөх М.Дагва нар сайдтай зөвшилцөж ярилцсаны дагуу Уул уурхайн хуулийн төслийг боловсруулах шаардлагагүй гэж тохиролцсон байна. Харин уг хуулийн төсөлд тусгасан асуудлуудыг Газрын хэвлийн тухай болон Ашигт малтмалын тухай хуульд оруулж шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахаар болсон" гэж тайлагнажээ.
 - Гэрээний 3.2.2 "Ашигт малтмалыг баяжуулах, ялгах бутлах ба хүдэр, баяжмалыг бөөнцөглөх аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм"-ийн төслийг боловсруулах" ажлын хүрээнд ... ажлын хэсэг 2 удаа хуралдан өмнөх ажлын хэсгийн боловсруулсан" гэж дутуу тайлагнажээ.

ЗӨВЛӨМЖ

1. ТЗУГ нь Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан "Мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам"-ын 1 дүгээр хавсралтын 6.3-т: "Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3 дахь хэсэгт заасны дагуу гэрээний биелэлтийг хагас, бүтэн жилээр дүгнэнэ" гэсэн хугацааг баримталж, ХШҮДАГ-т ҮДГ-г ирүүлэх,
2. Байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнээс Төсвийн ерөнхийлөн захирагчийн тусгайлан сонгосон тусгай арга хэмжээ бүрийн дугаарыг заах,
3. Үр дүнгийн гэрээний биелэлтийг бүрэн гүйцэд тайлагнаж холбогдох тушаал шийдвэр болон албан бичгүүдийн огноо, дугаарыг тодорхой дурдах;
4. Арга хэмжээ, ажил үйлчилгээний онцлогоос хамааран сар, улирал, хагас, бүтэн жилээр нарийвчлан төлөвлөх, мөн хүрэх түвшинг тодорхой заах
5. Хэрэгжилт удаашралтай байгаа ажил үйлчилгээг эрчимжүүлэх, тайлант онд багтаан хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах,

6. Цаашид өгсөн зөвлөмжийг биелүүлээгүй буюу хангалтгүй биелүүлсэн тохиолдолд хариуцлага тооцох саналыг эрх бүхий албан тушаалтанд уламжлан шийдвэрлүүлнэ.

Танилцсан:

ТНБД

Г.Нандинжаргал

ТЗУГ-ын дарга

М.Баяраа

Хянасан:

ХШҮДАГ-ын дарга

Ц.Одхүү

Хяналт-шинжилгээ, үнэлгээг нэгтгэж, тайлан боловсруулсан:

ХШҮДАГ-ын мэргэжилтэн:

С.Цэцэг-Өлзий

Б.Дашдолгор /18.09.03/